



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОМА-2023/84/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Даланзадгад хот

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Болормаа

Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn

Аудитор: С.Одончимэг

Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.02.24 № 87

танай _____-ны № _____-г

МАНДАЛ-ОВОО СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Д.АДИЛБИШ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мандал-Овоо сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Мандал-Овоо сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтнаас бусад албан тушаалтанд шатахуун олгосон, он дамжсан аймгийн мал хамгаалах санд төвлөрүүлэх өвс тэжээлийн өглөг, иргэдээс авах өвс тэжээлийн авлагыг барагдуулаагүй нь зэрэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 15 дугаар зүйлийн 15.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь батлагдсан орон тоогоор бүрэн ажиллаагүй, мэргэжлийн боловсон хүчний дутагдалтай, мэргэжилтнүүд олон солигдож байгаа нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

016020153

Аудитын гол асуудал

Говийн Оюу хөгжлийг дэмжих сангийн санхүүжилтээр “Эко сум” хог хаягдлын менежментийн төслийг хэрэгжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>88,404,213.60</u>	<u>146,185,418.60</u>
33	АВЛАГА	33,576,000.00	33,576,000.00
335	Бусад авлага	19,976,000.00	19,976,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	19,976,000.00	19,976,000.00
336	Зээлийн авлага	13,600,000.00	13,600,000.00
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	13,600,000.00	13,600,000.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	13,600,000.00	13,600,000.00
34	УРЬДЧИЛГАА	1,173,795.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	1,173,795.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	53,654,418.60	112,609,418.60
351	Түүхий эд материал	-	19,700,000.00
35110	Тусгай зориулалттай материал	-	19,700,000.00
354	Хангамжийн материал	53,654,418.60	92,909,418.60
35410	Бичиг хэргийн материал	794,275.00	794,275.00
35420	Аж ахуйн материал	26,352,143.60	78,092,143.60
35470	Бусад хангамжийн материал	26,508,000.00	14,023,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,544,702,317.32</u>	<u>3,337,634,671.62</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,544,702,317.32	3,337,634,671.62
392	Биет хөрөнгө	3,536,818,123.90	3,205,414,478.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,904,175,949.76	2,409,489,196.83
39202	Хуримтлагдсан элэгдэл	(294,150,514.69)	(359,150,523.53)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	95,560,000.00	170,568,684.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(53,553,916.41)	(90,389,350.37)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	354,456,897.00	361,556,897.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(135,756,493.17)	(185,396,998.23)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	104,057,232.90	104,057,232.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(37,529,768.42)	(55,971,046.73)
39214	Бусад үндсэн хөрөнгө	716,862,703.13	1,011,261,757.13
39215	Хуримтлагдсан элэгдэл	(166,231,266.20)	(209,538,670.84)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	48,927,300.00	48,927,300.00
393	Биет бус хөрөнгө	7,884,193.42	132,220,193.46
39301	Програм хангамж	3,100,000.00	3,100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,051,666.58)	(2,421,666.54)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,835,860.00	131,541,860.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,633,106,530.92</u>	<u>3,483,820,090.22</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>18,424,978.00</u>	<u>19,472,034.11</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	18,424,978.00	19,472,034.11
413	Өглөг	18,424,978.00	19,472,034.11
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	96,742.00	1,143,798.11
4136	Бусад өглөг	18,328,236.00	18,328,236.00
41361	Байгууллагад төлөх өглөг	18,328,236.00	18,328,236.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,614,681,552.92</u>	<u>3,339,642,056.11</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,614,681,552.92	3,339,642,056.11
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	436,264,167.64	436,264,167.64
51101	Өмч: - төрийн	436,264,167.64	436,264,167.64

512	Хуримтлагдсан үр дүн	2,914,358,981.83	2,639,319,485.02
51210	Өмнөх үеийн үр дүн	2,914,358,981.83	2,914,363,781.83
51220	Тайлант үеийн үр дүн	-	(275,044,296.81)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	264,058,403.45	264,058,403.45
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,633,106,530.92</u>	<u>3,359,114,090.22</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,220,642,158.00	450,120,633.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,234,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	12,234,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,234,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,234,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,208,408,158.00	450,120,633.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,845,082,958.00	57,615,233.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,796,174,216.00	48,600,716.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,365,142.00	7,219,517.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	46,543,600.00	1,795,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	363,325,200.00	392,505,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	363,325,200.00	392,505,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,462,517,446.71	704,877,853.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,462,517,446.71	704,877,853.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,429,231,597.95	627,066,410.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	166,263,697.61	166,223,843.48
210101	Үндсэн цалин	133,536,074.61	166,223,843.48
210102	Нэмэгдэл	32,727,623.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,893,348.56	20,687,627.66
210201	Тэтгэврийн даатгал	15,266,241.51	13,141,246.10
210202	Тэтгэмжийн даатгал	1,366,082.00	1,914,945.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,553,208.35	1,501,716.33
210204	Ажилгүйдлийн даатгал	333,979.98	375,429.06
210205	Эрүүл мэндийн даатгал	3,373,836.72	3,754,290.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,796,900.00	30,790,139.18
210301	Гэрэл, цахилгаан	3,601,800.00	3,021,244.18
210302	Түлш, халаалт	27,595,100.00	27,768,895.00
210303	Цэвэр, бохир ус	1,600,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	41,180,215.00	46,688,101.00
210401	Бичиг хэрэг	3,501,950.00	2,665,200.00
210402	Тээвэр, шатахуун	26,740,530.00	34,090,150.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,038,615.00	4,721,901.00
210404	Ном, хэвлэл	201,400.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,135,000.00	3,133,200.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,562,720.00	2,077,650.00
2105	Нормативт зардал	30,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	30,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,452,070.00	-
210604	Урсгал засвар	14,452,070.00	-
2107	Томилолт, зочны зардал	2,347,000.00	4,707,000.00
210702	Дотоод албан томилолт	2,347,000.00	4,707,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	67,631,981.00	55,042,830.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	67,631,981.00	55,042,830.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,082,636,385.78	302,926,869.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,869,715,428.00	82,929,902.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,425,300.00	394,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	211,495,657.78	219,602,967.21
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,285,848.76	77,811,442.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,776,753.00	21,140,236.90
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	10,497,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,776,753.00	10,642,636.90
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20,513,437.76	56,671,205.89
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,513,437.76	56,671,205.89
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	995,658.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	995,658.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(241,875,288.71)	(254,757,220.32)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,239,617.38	482,456,782.49
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,239,617.38	462,456,782.49
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	20,000,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(5,239,617.38)	(482,456,782.49)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(247,114,906.09)	(737,214,002.81)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,242,028,797.00	450,120,633.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,610,143.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	15,610,143.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,610,143.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,610,143.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,226,418,654.00	450,120,633.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,863,093,454.00	57,615,233.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,814,196,712.00	48,600,716.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,365,142.00	7,219,517.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	46,531,600.00	1,795,000.00

131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	363,325,200.00	392,505,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	363,325,200.00	392,505,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,242,028,797.00	448,920,633.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,242,028,797.00	448,920,633.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,208,742,948.24	370,617,592.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	165,970,679.00	165,128,446.37
210101	Үндсэн цалин	133,243,056.00	140,836,679.11
210102	Нэмэгдэл	32,727,623.00	23,791,740.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	21,758.49
210104	Урамшуулал	-	423,871.63
210105	Гэрээт ажлын хөлс	-	54,396.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,039,252.24	20,735,968.66
210201	Тэтгэврийн даатгал	15,266,241.51	14,112,086.01
210202	Тэтгэмжийн даатгал	1,511,985.68	1,678,069.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,553,208.35	1,318,935.42
210204	Ажилгүйдлийн даатгал	333,979.98	329,535.81
210205	Эрүүл мэндийн даатгал	3,373,836.72	3,297,342.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,970,390.00	29,616,344.18
210301	Гэрэл, цахилгаан	3,601,800.00	3,021,244.18
210302	Түлш, халаалт	28,768,590.00	26,595,100.00
210303	Цэвэр, бохир ус	1,600,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	40,648,365.00	38,000,011.00
210401	Бичиг хэрэг	3,121,950.00	2,665,200.00
210402	Тээвэр, шатахуун	26,739,680.00	25,402,060.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,038,615.00	4,721,901.00
210404	Ном, хэвлэл	201,400.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,135,000.00	3,133,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,411,720.00	2,077,650.00
2105	Нормативт зардал	30,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	30,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,944,000.00	-
210604	Урсгал засвар	12,944,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	2,347,000.00	4,707,000.00
210702	Дотоод албан томилолт	2,347,000.00	4,707,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	68,596,410.00	59,500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,596,410.00	59,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,862,196,852.00	52,929,822.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,860,922,052.00	52,535,822.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,274,800.00	394,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,285,848.76	78,303,040.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,776,753.00	21,140,236.90
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	10,497,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,776,753.00	10,642,636.90
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20,513,437.76	56,671,205.89
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,513,437.76	56,671,205.89
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	995,658.00	491,598.00

213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	995,658.00	491,598.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	<u>1,200,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	<u>1,200,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	<u>1,200,000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,200,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	1,200,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(1,200,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	436,264,167.64	264,058,403.45	2,914,338,781.83	3,614,661,352.92
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	4,800.00	4,800.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	436,264,167.64	264,058,403.45	2,914,343,581.83	3,614,666,152.92
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	124,706,000.00	-	-	124,706,000.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(275,044,296.81)	(275,044,296.81)
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	560,970,167.64	264,058,403.45	2,639,299,285.02	3,464,327,856.11

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	392,505,400.00	335,834,194.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	392,505,400.00	335,834,194.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	365,639,000.00	317,343,772.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	195,232,500.00	165,128,446.37
210101	Үндсэн цалин	156,372,200.00	140,836,679.11
210102	Нэмэгдэл	38,860,300.00	23,791,740.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	21,758.49
210104	Урамшуулал	-	423,871.63
210105	Гэрээт ажлын хөлс	-	54,396.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,404,000.00	20,735,968.66
210201	Тэтгэврийн даатгал	16,594,700.00	14,112,086.01
210202	Тэтгэмжийн даатгал	1,952,300.00	1,678,069.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,561,900.00	1,318,935.42
210204	Ажилгүйдлийн даатгал	390,400.00	329,535.81
210205	Эрүүл мэндийн даатгал	3,904,700.00	3,297,342.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,217,700.00	29,616,344.18
210301	Гэрэл, цахилгаан	4,100,000.00	3,021,244.18
210302	Түлш, халаалт	29,517,700.00	26,595,100.00
210303	Цэвэр, бохир ус	1,600,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	40,393,300.00	36,062,013.00
210401	Бичиг хэрэг	2,996,300.00	2,665,200.00
210402	Тээвэр, шатахуун	26,756,800.00	23,494,062.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,245,100.00	4,691,901.00
210404	Ном, хэвлэл	172,800.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,135,000.00	3,133,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,087,300.00	2,077,650.00
2105	Нормативт зардал	119,200.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	119,200.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,840,000.00	-
210604	Урсгал засвар	1,840,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	5,784,200.00	4,707,000.00
210702	Дотоод албан томилолт	5,784,200.00	4,707,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,973,100.00	60,700,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,973,100.00	60,700,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	675,000.00	394,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	175,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	394,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,866,400.00	18,490,421.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,866,400.00	18,490,421.90
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,866,400.00	10,497,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,000,000.00	7,992,821.90
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	392,505,400.00	335,834,194.11
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	392,505,400.00	335,834,194.11
132001	Орон нутгийн төсвөөс	392,505,400.00	335,834,194.11

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	57,123,635.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	57,123,635.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	54,473,820.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,937,998.00
210402	Гээвэр, шатахуун	1,907,998.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,535,822.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,535,822.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,649,815.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,649,815.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,649,815.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	57,615,233.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	57,615,233.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,600,716.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,219,517.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,795,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 243.5 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 243.5 сая төгрөгийн алдааг залруулж ажилласан. Үүнд:

- Тус ЗДТГ-ын нэр дээрх эзэмших эрхтэй 7 газрыг бүртгэхдээ Засгийн газрын санг нэмэгдүүлж тайлагнаагүй
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд орон нутгийн данснаас төвлөрүүлсэн шилжүүлгээр санхүүжилтийн эх үүсвэрийг бууруулаагүй тайлагнасан
- Мөнгөн гүйлгээний тайланд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1.2 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжийг хөрөнгө оруулалтын зардлаар бүртгэж тайлагнаагүй
- Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн 56.6 сая төгрөгийг 131105 төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого дансанд тайлагнасан байна
- Орлого үр дүнгийн тайланд цалингийн зардлыг зөрүүтэй илэрхийлсэн байна.

Аудитаар нийт 40.9 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 39.4 сая төгрөгийн 2 зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1.5 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй байна.

3.2 Албан шаардлага

-Тайлант онд ажиллагсадтай холбоотой 1.2 сая төгрөгийн өглөг үүсгэсэн, он дамжсан аймгийн мал хамгаалах санд өгөх өвс тэжээлийн 18.3 сая төгрөгийн өглөг, иргэдээс авах өвс тэжээлийн 19.9 сая төгрөгийн авлагыг тус тус барагдуулж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 *"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 *"хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх"*-д заасантай тус тус нийцэхгүй байна

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтгүй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Байгууллагын дотоод журамд заасны дагуу албан хаагчдад олгох мөнгөн шагнал урамшууллын зардлаас өргөмжлөл жааз, бэлэг дурсгал, эм, аарц зэрэг материал эд хогшил бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан *"Зардлын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"*-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зардлын эдийн засгийн ангиллыг ашиглах заавард заасны дагуу төсвийг зориулалтын дагуу зарцуулж ажиллах

Илрүүлэлт 2: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай ЗГ-ын тогтоол батлагдаж суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтныг хязгаарласантай холбоотойгоор тус байгууллага үндсэн үйл ажиллагаанаас бусад тохиолдолд албан хаагчдад шатахуун зарцуулж ажилласан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 *"Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно"*-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн чиг үүргийг гүйцэтгэх ажлаас бусад тохиолдолд төсвийн хөрөнгийг хэмнэлттэй үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитыг газарт 2023 оны 10 дугаар сарын 02-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тус ЗДТГ-ын нэр дээрх эзэмших эрхтэй 7 газрыг бүртгэхдээ Засгийн газрын санг нэмэгдүүлж тайлагнаагүй байна.	1	124,706.0			1	124,706.0	1	124,706.0				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд орон нутгийн данснаас төвлөрүүлсэн шилжүүлгээр санхүүжилтийн эх үүсвэрийг бууруулаагүй тайлагнасан байна.	1	57,162.8			1	57,162.8	1	57,162.8				
Мөнгөн гүйлгээний тайланд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1,200.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг хөрөнгө оруулалтын зардлаар бүртгэж тайлагнаагүй байна	1	1,200.0			1	1,200.0	1	1,200.0				
Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн 56,671.2 мянган төгрөгийг 131105 төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого дансанд тайлагнасан байна	1	56,671.2			1	56,671.2	1	56,671.2				
Орлого үр дүнгийн тайланд цалингийн зардлыг зөрүүтэй илэрхийлсэн байна.	1	3,770.6			1	3,770.6	1	3,770.6				
ДҮН	5	243,510.6			5	243,510.6	5	243,510.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд ажиллагсадтай холбоотой 1,143.7 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн, он дамжсан аймгийн мал хамгаалах санд өгөх өвс тэжээлийн 18,328,236.2 мянган төгрөгийн өглөг, иргэдээс авах өвс тэжээлийн 19,976.0 мянган төгрөгийн авлагыг тус тус барагдуулж ажиллаагүй байна.	1	39,403.0			1	39,403.0						
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай ЗГ-ын тогтоол батлагдаж суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтныг хязгаарласантай холбоотойгоор тус байгууллага үндсэн үйл ажиллагаанаас бусад тохиолдолд албан хаагчдад шатахуун зарцуулж ажилласан байна.	1	0					1	0				
Байгууллагын дотоод журамд заасны дагуу албан хаагчдад олгох мөнгөн шагнал урамшууллын зардлаас өргөмжлөл жааз, бэлэг дурсгал, эм, аарц зэрэг материал эд хогшил бэлтгэсэн байна	1	1,534.5					1	1,534.5				
Дүн	3	40,937.5			1	39,403.0	2	1,534.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
19 мэдээлэл хугацаа хоцруулж мэдээлсэн, дараа жилийн төсвийн төсөл, худалдан авах ажиллагааны тайлан, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлбарыг үнэн зөв оруулаагүй, хөрөнгө зарцуулсан 55,079,745 төгрөгийн 36 шийдвэр, 5 сая төгрөгөөс дээш орлогын 17,928,600 төгрөгийн 2 ажил гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш зарлагын 95,238,127.29 төгрөгийн 10 ажил гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын 51,997,160 төгрөгийн 2 ажил гүйлгээг өссөн дүнгээр мэдээлээгүй, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг тус тус оруулаагүй байна	1	220,243.6			1	220,243.6		
Дүн	1	220,243.6			1	220,243.6		